ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар багийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2023/38/НА-СТА-ТШЗ

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2023 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Аудитын санал дүгнэлт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.01 № А-6/34

танай_____-ны №_____-т

САЙНШАНД СУМЫН
5 ДУГААР БАГИЙН ЗАСАГ
ДАРГА Ч.БАДАМЛЯНХУА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын 5 дугаар багийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын 5 дугаар багийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Сахилгын шийтгэл авсан 1 албан хаагчид сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа болоогүй байхад урамшуулал олгосон мөн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0100003:3

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,977.9	5,429.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	590,804.1	597,106.1
	Нийт хөрөнгийн дүн	**595,782.0**	**602,535.5**
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	595,782.0	602,535.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**595,782.0**	**602,535.5**
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	194,687.0	206,489.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	215,410.5	199,736.2
	Үйл ажиллагааны үр дүн	**-20,723.5**	**6,753.5**
	Үйл ажиллагааны бус үр дүн	-17,737.1	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	**-38,460.6**	**6,753.5**
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	186,915.0	177,731.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	186,215.0	177,731.7
	Үйл ажиллагааны ЦМГ	**700.0**	**-**
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	**700.0**	**-**
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	**-**	**-**
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	**-**	**-**
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**-**	**-**
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	**-**	**-**
	Тайлант оны үр дүн	**-**	**6,753.4**
	Эцсийн үлдэгдэл	**595,782.0**	**602,535.5**
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	183,099.9	176,881.7
	Урсгал зардал	183,099.9	176,881.7
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	183,099.9	176,881.7
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	183,099.9	176,881.7
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах;
- Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;
- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;

- Бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах.

Сайншанд сумын 5 дугаар баг нь зорилгоо дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:
- Төрийн анхан шатны үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх.

Байгууллагын 2022 онд дэвшүүлсэн зорилт:
- "Эко хот 2022"

Дөрөв. Аудитын гол асуудал

Сахилгын шийтгэл авсан 1 албан хаагчид сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа болоогүй байхад урамшуулал олгосон мөн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 158 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 12 орлого, Засаг даргын гаргасан 5 захирамжийг бүрэн байршуулсан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 0.5 сая төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж өгсөн.

7.1 Төлбөрийн акт

Тус байгууллагын нярав Д.Батбаяр нь 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр сахилгын шийтгэл авсан бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа болоогүй байхад буюу 2022 оны 08 дугаар сард 460,931 төгрөгийн урамшуулал олгосон байна.

7.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Тодруулгатай холбоотой асуудал

<u>Илрүүлэлт:</u>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулаагүй нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх үр дагавар үүсэх бөгөөд УСНББОУС 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д *"аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах"*, 20 дугаар зүйлийн 20.2.2-д *"аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль, дүрэм, журам стандартад нийцүүлэн боловсруулж, батлуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

8.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

Д/д	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлттүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгхөөс татгалзсан
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
	Нийт	1	1			1			

8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа болоогүй байхад урамшуулал олгосон байна	1	460.9	1	460.9	-	-	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулаагүй байна	1	-	-	-	-	-	1	-	-	-
Дүн	**2**	**460.9**	**1**	**460.9**	**-**	**-**	**1**	**-**	**-**	**-**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-